



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

# e-journal AMCHAM CSR

Issue No. 17 / Q2 2025



**GOLOMT BANK**  
Committed to and Investing in Excellence

**GUND INVESTMENT**

**MONCEMENT**  
BUILDING BETTER FUTURE

**MSM**

# ГОЛОМТ БАНКНЫ 2024 ОНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН НИЙТЛЭГДЛЭЭ

Голомт банк нь 2024 оны Тогтвортой хөгжлийн тайлангаараа дамжуулан тогтвортой хөгжлийн стратеги, хариуцлагатай банкны зарчмуудын хүрээнд баримталж буй бодлого, байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хэрэгжүүлж буй сайн туршлагуудаас танилцуулж байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЗАСАГЛАЛ

ТОГТВОРТОЙ, НОГООН САНХҮҮЖИЛТ

ТОГТВОРТОЙ, НОГООН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НИЙГЭМ

ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛ

ТООН ТӨДРҮҮЛЭГ

## ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ОНЦЛОХ МЭДЭЭЛЛҮҮД

**875**  
ТЭРБУМ ТӨГРӨГ

2019 оны 3-р улирлаас 2024 оны 4-р улирлын хооронд 875 (2023: 565) тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгосон бөгөөд үүнээс 309 (2023: 243) тэрбум төгрөгийг 2024 онд олгосон байна.



**265**  
ТЭРБУМ ТӨГРӨГ

Ногоон зээлийн багц 265 (2023:183) тэрбум төгрөг болсон байна. Энэ нь:  
Банкны нийт зээлийн багцын 3.6%  
Зах зээлийн 19.6% хувийг эзэлж байна



**2030: 30%** ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ  
**2050: 50%** 2030: 30% (суурь өгөгдөл 2023)  
2050: 50% (суурь өгөгдөл 2023)

**2030: 5%** УСНЫ НӨӨЦ  
**2050: 10%** 2030: 5% (суурь өгөгдөл 2023)  
2050: 10% (суурь өгөгдөл 2023)

**ЭРЧИМ ХҮЧ 30%**

2030 он гэхэд Эрчим хүчний хэрэглээг 30% бууруулах (2023 суурь үзүүлэлтээс)

**УСНЫ ХЭРЭГЛЭЭ 5%**

2030 он гэхэд Усны хэрэглээг 5% бууруулах (2023 суурь үзүүлэлтээс)

**ДАХИВАР ХОГ ХАЯГДАЛ 30%**


2030 он гэхэд Дахивар хог хаягдлын хэмжээг 30% нэмэх (2023 суурь үзүүлэлтээс)

**ХУДАЛДАН АВАЛТ 50% НОГООН**

Тогтвортой, ногоон худалдан авалтын стандартыг батлан 2030 он гэхэд нийт худалдан авалтын 50%-ийг ОУ-ын шаардлагатай нийцүүлж тогтвортой, ногоон худалдан авалтаар бүрдүүлэх зорилт тавив.



ТОС ОНЦЛОХ БАНК  
2024



ТЭРБУМ МОД САНГИЙН  
ШИЛДЭГ ДЭМЖИГЧ 2024




TOP-THIRD  
S&P БОНЗ ҮНЭЛГЭЭ

8


Голомт банк нь стратеги, зорилго зорилтуудаа НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр (НҮББОХ), Санхүүгийн санаачилга-Хариуцлагатай Банкны Зарчмууд зэрэг олон улсын стандартуудтай уялдуулан байгаль орчин, нийгэм, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулахыг зорин ажиллаж байна.

## 2024 оны тогтвортой хөгжил, ногоон санхүүжилтийн онцлох үзүүлэлтүүдээс дурдвал:

- Тайлант онд нийт 309 тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгож, ногоон зээлийн багцаар дамжуулан нийт 4,700 гаруй ажлын байр, 99 тэрбум төгрөгийн нэмүү өртөгийг бий болгон тогтвортой хөгжлийн зорилгуудад хувь нэмрээ оруулсаар байна.
- Хүлэмжийн хийн протокол болон Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл (PCAF) аргачлалын дагуу банкны өөрийн үйл ажиллагаа болон санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг хамрах хүрээ 1,2,3-ын хүрээнд тооцоолж (нийт 1.8сая тнCO<sub>2</sub>e), дотоод аудитын газраас баталгаажуулалт авав.
- Өөрийн үйл ажиллагааны хүлэмжийн хийн ялгарлыг 2023 онтой харьцуулахад 56 хувиар бууруулсан амжилттай байна. Өөрийн үйл ажиллагаа болон санхүүжилтээр дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлыг 2030 онд 30 хувиар, 2050 онд 50 хувиар бууруулах зорилтод хүрэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- Голомт банк нь 2024 оны тогтвортой санхүүжилтийн шилдэг банк, Тэрбум мод сангийн шилдэг дэмжигч байгууллагаар шалгарсан байна. Мөн төв оффисын барилга АНУ-ын ногоон барилгын зөвлөлөөс LEED O+M стандартын “GOLD” түвшний гэрчилгээг хүртэв.
- Харилцагч болон ажилтнуудад тогтвортой, ногоон санхүүжилтийн сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж (21 ААН, 386 борлуулалтын менежер) ногоон эдийн засагт шилжих санаачилгуудыг дэмжин ажиллаж байна.



9



10

Та бүхэн [энд дарж](#) бүрэн тайлантай танилцана уу.



# “ГҮНД ИНВЕСТМЕНТ” ХОЛДИНГ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ДХИС-ИЙН СИСТЕМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН ТАНХИМЫГ ТОХИЖУУЛЖЭЭ



“Гүнд Инвестмент” холдинг нийгмийн хариуцлагын хүрээнд үйл ажиллагааг нь дэмжин ажилладаг “Системийн инженерчлэлийн институт” ТББ ДХИС-ийн Удирдлагын академитай хамтын ажиллагааны гэрээ үзэглэж, хамтын ажиллагааны эхлэл болгон системийн инженерчлэлийн танхимыг тохижуулан хүлээлгэн өглөө.

Системийн инженерчлэлийн институт нь системийн инженерчлэлийн онолын үзэл баримтлалыг таниулах, нийгмийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэдэг төрийн бус байгууллага билээ.



Тус институт нь системийн инженерчлэлийн онолын үзэл баримтлалыг таниулах, нийгмийн тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгааны ажлуудыг гүйцэтгэдэг төрийн бус байгууллага билээ. Хамтын ажиллагааны хүрээнд мөн ДХИС-ийн ахисан түвшний боловсролын хөтөлбөрт системийн инженерчлэлийн онол, арга зүйн агуулгыг энэ хичээлийн жилээс эхлэн албан ёсоор нэвтрүүлж, анхны төгсөгчид нь Удирдлагын академийн стратегийн I, II дамжааны суралцагчид болж, тус сургуулийн Удирдлагын академийн захирал, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа Ц.Азбаяр, “Системийн инженерчлэлийн институт” ТББ-ыг үүсгэн байгуулагч Д.Жаргалсайхан, тус ТББ-ын УЗ-ын дарга, “Гүнд Инвестмент” холдингийн Гүйцэтгэх захирал Ж.Бат-Ирээдүй нараас хамтарсан гэрчилгээгээ гардан авав.



Системийн инженерчлэлийн онол нь нарийн төвөгтэй үйл ажиллагааг загварчлах, асуудлыг цогцоор нь танин мэдэж шийдвэрлэх багц шийдлийг санал болгох зорилготой салбар хоорондын инженерийн ухаан юм. Үг онолын үзэл баримтлалыг “Гүнд Инвестмент” холдинг хөрөнгө оруулсан мэдээллийн технологи, боловсрол, даатгал, санхүү, хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, гарааны бизнесийн зөвлөх үйлчилгээ, спортын менежмент зэрэг салбарын 20 орчим төслүүддээ суулган практикт ашигласаар ирсэн бөгөөд системийн инженерчлэлийн ухааныг хөрөнгө оруулалттай холбон ажилласны 10 жилийн ойгоо ирэх онд тэмдэглэх гэж байна. Тус компанийн хөрөнгө оруулсан бүх бизнесүүд системийн инженерчлэлийн онол арга зүйд суурилан үйл ажиллагаагаа явуулдаг онцлогтой аж.



## MONCEMENT BUILDING MATERIALS LLC IS MAKING A MEANINGFUL CONTRIBUTION TOWARD IMPROVING ACCESS TO EDUCATION AND PROMOTING EQUAL OPPORTUNITIES FOR CHILDREN IN REMOTE AREAS.

Moncement Building Materials LLC, has formalized contribution agreement with UNICEF to champion equitable access to education in Mongolia's most remote and underserved communities.



Anchored in the companies' long-standing commitment to corporate social responsibility, the partnership underscores a shared vision: that every child, regardless of geography, deserves access to quality learning opportunities.

As part of the initiative, Moncement will lead the renovation and technological modernization of the digital classroom at Urgun Soum School in Dornogovi Province—a vital step toward building an inclusive and future-ready educational environment. The program further aims to mitigate persistent student absenteeism and to enhance instructional capacity through the implementation of specialized summer training programs for educators.



In line with these efforts, the “Summer School” program has successfully launched in Urgun Soum. This special initiative is designed for primary and secondary school students, providing them with a meaningful opportunity to build confidence in their future and inspiring them to pursue their dreams through education.

Speaking at the agreement signing, Ms. N. Munkhnasan, Chairwoman of Monpolymet Group, emphasized the increasingly vital role of the private sector in addressing social development challenges.

“While the private sector contributes substantially to the national budget through taxes,” she noted, “inefficiencies in public resource allocation often require businesses to step in and take responsibility for foundational areas such as education and healthcare. True progress demands not only investment, but intention.”

Recognizing digital literacy as a critical tool for empowerment, Monpolymet Group, through its partnership with UNICEF, is committed to transforming rural learning environments by expanding access to technology and creating more engaging, learner-centered spaces. The broader initiative includes:

|                                                                 |                                                                           |
|-----------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|
| Renovating e-learning classrooms                                | Equipping students with digital learning tools                            |
| Delivering capacity-building programs for teachers and students | Strengthening community participation to ensure long-term sustainability. |

Through this collaboration, Moncement and its partners reaffirm their belief that education is the foundation of opportunity and progress begins when the private sector leads with purpose.

Previously, Moncement, a subsidiary of Monpolymet Group, partnered with UNICEF to support early childhood development through the “Teacher with Tablet” initiative. The results of this project will be presented in August.

## МСМ ГРУППИЙН АЖИЛТНУУД WINGS FOR LIFE BY RED BULL ОЛОН УЛСЫН ХАНДИВЫН ГҮЙЛТЭД ОРОЛЦЛОО



МСМ Группийн ажилтнууд анх удаа Red Bull-ээс жил бүр зохион байгуулдаг олон улсын “Wings for Life World Run” нийгмийн сайн сайхны төлөөх гүйлтийн тэмцээнд оролцлоо. Тус уралдааны хураамжийг 100% нуруу нугасны гэмтлийн эмчилгээний судалгаанд зориулдаг юм.

МСМ-чүүд нийт 523.4км зам туулж, нийт 9,997 багаас 367 дугаарт эрэмбэлэгдэн шилдэг 5%-д багтаж, албан ёсны аппликэйшн ашигласан оролцогчдын тоогоор дэлхийд #140-д жагссан бахархам амжилтыг үзүүллээ.

Бид хамтын хүчин чармайлтаараа нийт 1,073 еврогийн хандив босгож, Швед, Герман, Итали, Сингапур, Украин зэрэг улсын хамт олонтой мөр зэрэгцэн гүйсэн нь бидний бас нэг онцлох бахархал боллоо.

Дэлхийн хэмжээнд “Wings for Life World Run” уралдаан өмнөх амжилтаа ахиулж, нийт 310,719 оролцогчтой болсон бөгөөд нэг оролцогч дунджаар 12.4 км гүйж, нийт 3.85 сая км туулсан байна. Энэ нь дэлхийг 64 удаа тойрсонтой тэнцэхүйц үзүүлэлт юм. Тус уралдааны хүрээнд ойролцоогоор 9.7 сая ам.доллар хандив цугларсан ба энэ нь 100% нугасны гэмтлийн судалгаанд зориулагдах юм.

Нийгмийн сайн сайхан, хүүхдийн эрх, боловсрол хөгжилд урт хугацааны бодит хувь нэмэр оруулж буй төслийг дэмжин ажиллах нь бидний нийгмийн хариуцлагын зорилго билээ.



